



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/49

Рашаант сум

**Ой хээрийн түймрээс урьдчилан
сэргийлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.12, 18.2.17 дахь заалт, Шадар сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/84 дүгээр тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга, сургалт сурталчилгааны ажлыг бүхий л хэлбэрээр зохион байгуулж баг дээрээ байнгын ажиллахыг багийн Засаг дарга, байгаль хамгаалагч нарт үүрэг болгосугай.

2.Ой хээрийн түймрийн эрсдэлтэй улиралд эргүүл жижүүрийг ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүд тус бүр гарган ажиллуулж дүнг Засаг даргын тамгын газарт тухай бүр мэдээлж байхыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (М.Билэгдэмбэрэл), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Орон нутгийн бэлэн байдлыг хангах ой хээрийн түймрийн улмаас учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор түймрийн 1,2 дугаар ээлжээр ажиллах иргэд, албан хаагчдыг ажлын багаж хэрэгсэл, хувцас, эм, 3 хоногийн хоол хүнс зэрэгтэй бэлэн байлгаж нэрсийг нь Засаг даргын тамгын газарт гарган өгч тайлагнахыг багийн Засаг дарга нар, Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Б.Баттогтох), Цэнгэлийн ирээдүй цэцэрлэгийн эрхлэгч (Ч.Отгон-эрдэнэ), Хүн эмнэлгийн эрхлэгч (Б.Саруул), Соёлын төвийн эрхлэгч (Л.Баярцэнгэл) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Гарсан гал түймрийг цаг алдалгүй илрүүлж бага талбайд унтраах арга хэмжээ авч ажиллахыг багийн Засаг дарга нарт хариуцуулсугай.

5.Ой хээрийн түймэр гарсан даруй эзэн холбогдогчийг олж тогтоон, унтраах арга хэмжээнд ард иргэд, тээврийн хэрэгслийг дайчлан оролцуулахыг сумын Хэсгийн төлөөлөгч (Н.Энхжил)-д даалгасугай.

6706011086

6.Хуурайшилтын зэрэглэл өндөртэй цаг үеүдэд цаг агаарын урьдчилсан мэдээг цахим сүлжээ ашиглан сумын шуурхай штаб, багийн Засаг дарга нар, иргэдэд цаг алдалгүй мэдээлж ажиллахыг Рашаант цаг уурын өртөөний дарга (Э.Энхмаа)-д үүрэг болгосугай.

7.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Т.Отгонцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

A red square official stamp is partially visible behind a large, stylized handwritten signature in black ink. The signature appears to be 'Б.Алтангэрэл'.